

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023. 12. 27

Байгууллагын нэр:

Тээврийн цагдаагийн алба

Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Замын цагдаагийн газар нутаг дэвсгэр
хариуцсан Замын цагдаагийн хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-3

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Олимпийн
гудамж, өөрийн байр.

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй
байдал үүссэн, террорист халдлага, онц
болон дайны байдал зарласан, онц ноцтой
гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй
тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд
ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг
журам, Баримт бичгийн стандарт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Архив, албан
хэрэг хөтлөх" журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Албан тушаалын зорилт:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн
хэмжээнд нэгтгэх, хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг сахиулах, замын хөдөлгөөний
аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга зүй, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг
хангах, боловсруулах болгох чиглэлээр холбогдох санал боловсруулах дээд шатны
байгууллагад хүргүүлэх.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлцсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг
үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Хууль тогтоомж дүрэм журам, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох ажилд хяналт, тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах:</p> <p>1.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутгийн захиргааны төрийн болон төрийн бус байгууллагаас зохион явуулж буй үйл ажиллагаанд оролцох, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах:</p> <p>1.3.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохион байгуулж, хамгаалалт хөдөлгөөн зохицуулалтын нууцлалыг чанд хадгалах:</p> <p>1.4.Цагдаагийн, байгууллагаас Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай харилцан хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангуулах, энэ журмын нэмэлт, өөрчлөлт оруулах санал танилцуулга боловсруулж, удирдах дээд шатны байгууллагад хүргүүлэх:</p> <p>1.5.Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн өндөр хэмжээний албан тушаалтан, хамгаалуулагчийг баяр ёслол олон нийтийн болон бусад арга хэмжээнд оролцох, авто тээврийн хэрэгслийр зорчих байгуулах, эрсдэлийг тооцох, Замын цагдаагийн хэлтсийн хамгаалалтын үйл ажиллагааг удирдах:</p> <p>1.6.Замын цагдаагийн хэлтсийн орон тоо замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих үйлд ажиллагаанд шаардагдах хүн хүч техник, тусгай хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг</p>	<p>Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хяналт зохицуулалтын үйл ажиллагаа сайжруулсан байна.</p>	T, Г

	<p>тодорхойлох, бүтэц, орон тоог боловсронгуй болгохтой холбогдсон асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах:</p> <p>1.7.Хууль сахиулах зохицуулах зорилгоор тээврийн хэрэгсэл түр саатуулах, зөөж шилжүүлэх ажиллагааг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих:</p> <p>1.8.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр шаардлагатай мэдээ шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах:</p> <p>1.9.Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, байгууллагын дотоод журмыг мөрдүүлэх, хяналт тавих:</p> <p>1.10.Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтэд хяналт тавих.</p> <p>1.11.Хэлтсийн алба хаагчдын сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн ажлуудыг зохион байгуулах:</p> <p>1.12.Холбогдох журмын дагуу хариуцсан хэлтсийн болон алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан өргөдөл, гомдол дотоод хяналт шалгалт зохион байгуулах, сахилга ёс зүйн зөрчлийг шалгаж тогтоох, үнэлэлт дүгнэлт өгч илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах.</p>		
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийг хэрэгжүүлж буй байдагд дүн шинжилгээг хийх, дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, зааварчилга, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах:</p> <p>2.2.Замын хөдөлгөөнийг зохицуулах хяналт тавих, хамгаалалтын чиг үүргийн бодлого, стандарт, дүрэм, журам заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах боловсронгуй болох чиглэлээр холбогдох санал, танилцуулга боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх:</p>	<p>Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл боломж сайжирсан байна.</p>	<p>Г, Х</p> <p>Т, Г</p> <p>Т, Г</p> <p>Т, Г</p>

	<p>2.3.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, энэ ажлын хүрээнд цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах, оролцох, үр дүнг танилцуулах:</p> <p>2.4.Хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх, дүрэм журмыг сахиулах, замын хөдөлгөөнд хяналт тавих, зөрчлийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах:</p> <p>2.5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих, хөдөлгөөн зохицуулах, хамгаалалтын үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судлах, танилцуулах</p>		
3 дугаар зорилтын хүрээнд	<p>3.1.Улсын Их Хурал, Засгийн газар Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, харьяа нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах:</p> <p>3.2.Замын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулах, дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, бусад байгууллагыг мэдээллээр хангах:</p> <p>3.3.Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх шууд удирдах даргаас хариуцуулсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах:</p> <p>3.4.Тээврийн цагдаагийн албаны болон хэлтсийн дотоод журмыг мөрдүүлж, алба хаагчдын болон байгууллагын аюулгүй байдлыг хангах, өмч, эд хөрөнгө, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт бүртгэл, зарцуулалт, ашиглалтад хяналт тавих ажлыг зохион байгуулах:</p> <p>3.5.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх чөлөөг хүндэтгэн</p>	<p>Хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна..</p>	<p>Г, Х</p> <p>Г, Х</p>

	<p>шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"ийг чанд мөрдөх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх, явцуу эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах:</p> <p>3.6. Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлэх:</p> <p>3.7. Байгууллага, алба хаагч бусад ажиллагсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажилд бүх талын тусламж үзүүлэх.</p>		Г, Х
--	--	--	------

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, Авто инженерчлэл (071601), Авто машин ашиглалт, авто аж ахуй (071602), Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл (071604)		
Мэргэшил	Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 12-оос доoshгүй жил ажилласан, үүнээс тасгийн дарга түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доoshгүй жил ажилласан байх.		
Үр чадвар	Удирдах зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах. -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах чадвартай. -Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж зохих заавар чиглэл өгөх.	
	Дүн шинжилгээний хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж дүгнэх -Шийдвэрийн шууд болон шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх.	
	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх:	
	Манлайлах	-Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх: -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах: -Байгууллагын үйл ажиллагааны шинэгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх	
	Бусад	-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх: -Албан хэргийн хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийг дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх: -Компьютерын Microsoft office Word, Excel, Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ


Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:
Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага:
 -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУПАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.GANZORIG	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр. Дугаар: 1/104	
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  T.SUHBOLD	
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

Танилцсан:

Албан тушаалтан:.....
20...оны дугаар сарын -ны өдөр